



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 28 өдөр

Дугаар А/102

Шивээговь сум

Коронавируст халдвар (Ковид-19)-ын
эрсдэлээс урьдчилан сэргийлэх хариу
арга хэмжээ авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5.в, 29.1.6.а, 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8, Захиргааны ерөнхий хуулийн 22 дугаар зүйлийн 22.1, 28 дугаар зүйлийн 28.1.2, 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Засгийн газрын 2021 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 154 дүгээр “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай” тогтоол, аймгийн Засаг даргын 2021 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн А/180 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Коронавируст халдвар (Ковид-19)-ын батлагдсан тохиолдол нэмэгдэж байгаатай холбогдуулан сумын хэмжээнд 2021 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 06:00 цагаас 2021 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 06:00 цаг хүртэлх хугацаанд Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын 3 дугаар зэрэг (Улбар шар түвшин)-т шилжүүлсүгэй.

2. Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын 3 дугаар зэрэг (Улбар шар түвшин)-т шилжсэнтэй холбогдуулан хязгаарлалт тогтоох төрийн байгууллага, хуулийн этгээд, иргэдийн үйл ажиллагааг хавсралтаар баталсугай.

3. Шивээговь /22 дугаар/ зөрлөгийн гарам дээр 24 цагийн байнгын хяналтын цэгийг ажиллуулж, Улаанбаатар хот болон халдварын бүс нутгаас ирэх хүсэлтэй харьяаллын бус иргэдийг хүндэтгэн үзэх шалтгаан (буяны ажил, эрүүл мэнд, хүнс болон эм эмнэлгийн хэрэгсэл, шатахууны түгээлт, тээвэр)-аас бусад тохиолдолд сум руу нэвтрүүлэхгүй байх, иргэд, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хяналт тавьж, эргүүл шалгалтыг хийх, 22 дугаар зөрлөгийн гармын хяналтын постоор орох, гарах хөдөлгөөнийг оройн 21:00 цагт хааж, хүн, тээврийн хэрэгслийг нэвтрүүлэхгүй байхыг сумын Цагдаагийн хэсгийн дарга, цагдаагийн хошууч (Б.Шинэбаяр)-т үүрэг болгосугай.

4. Улаанбаатар хот болон халдварын голомтын бүс нутгаас хүндэтгэн үзэх шалтгаан (буяны ажил, эрүүл мэнд, албан томилолт)-аар ирж буй иргэдээс түргэвчилсэн шилжилгээг үнэ төлбөргүй авах, бусад шалтгаанаар ирж байгаа иргэдээс түргэвчилсэн шинжилгээг 25000 (хорин таван мянга) төгрөгөөр авч сум руу нэвтрүүлэхийг Эрүүл мэндийн төвийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Х.Сувданцэцэг)-т, гарам дээр ажиллах Эмнэлгийн шинжилгээний цэгт

Шивээ-Овоо хувьцаат компанийн Гамшгаас хамгаалах Мэргэжлийн ангийн эмч нарыг татан оролцуулж, ажиллуулахыг Шивээ-Овоо хувьцаат компанийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хэлтсийн дарга (Ц.Амарсайхан) нарт тус тус үүрэг болгосугай.

5. Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын 3 дугаар зэрэг (Улбар шар түвшин)-д шилжсэн хугацаанд сул болон өндөр агууламжтай архи, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг хориглож, худалдаа, үйлчилгээний нийт байгууллагуудын ажиллах цагийн хуваарийг 08:00-20:00 цагийн хооронд байхаар тогтоож, хяналт тавьж ажиллахыг (Хүнс, жижиг дунд үйлдвэр, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн Д.Эрдэнэтулга), Цагдаагийн хэсгийн дарга, цагдаагийн хошууч (Б.Шинэбаяр)-т үүрэг болгосугай.

6. Халдвар хамгааллын дэглэмийг мөрдөн, хүн хоорондын зай барьж, ажил гэр гэсэн маршрутаар хөдөлгөөнд оролцохыг Төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагын ажилтан, албан хаагчид, нийт иргэдэд үүрэг болгосугай.

7. Тандалт судалгаа, халдварын голомтыг тогтоох ажлыг эрчимжүүлэх, Улаанбаатар хот болон халдварын бүс нутгаас ирж буй иргэдэд журмын дагуу хяналт тавьж ажиглан, халдвар хамгааллын дэглэмийг мөрдүүлж ажиллахыг Эрүүл мэндийн төвийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Х.Сувданцэцэг), Цагдаагийн хэсгийн дарга, цагдаагийн хошууч (Б.Шинэбаяр), Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Отгонжаргал) нарт үүрэг болгосугай.

8. Нийтийн эзэмшлийн гудамж талбай, хүүхдийн тоглоомын талбайд бөөгнөрөл үүсгэхгүй хүүхдэд тавих эцэг, эхийн хараа хяналтыг сайжруулж, олон нийтийн газраар дагуулж явахгүй байх, хүн хоорондын зай барин, амны хаалтыг тогтмол зүүж, гэртээ зочин урихгүй, айл хотлоор орохгүй, халдварын бүс нутаг руу зорчихгүй, халдвар хамгааллын дэглэмийг чанд мөрдөхийг нийт иргэдэд уриалсугай.


9. Иргэдэд Коронавируст халдвар (Ковид-19)-аас урьдчилан сэргийлэх талаар сэрэмжлүүлэг, зарлан мэдээллийг олон нийтийн мэдээллийн сувгаар дамжуулж, чанга яригчаар тогтмол мэдээллэн ажиллахыг сумын Онцгой комиссын гишүүн (Э.Төрмандах)-д үүрэг болгосугай.

10. Төрийн болон хуулийн этгээд, аж ахуйн нэгж, байгууллагаар үйлчлүүлж байгаа иргэдийг Коронавируст халдвар (Ковид-19)-ын эсрэг QR кодоор бүртгэлжүүлэх, халдвар хамгааллын дэглэм, холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг мөрдөж ажиллах, 0-12 насны хүүхдэд үйлчлэхгүй байхыг албан байгууллага, аж ахуйн нэгжийн дарга, эрхлэгч, захирал нарт үүрэг болгосугай.

11. Захирамжийн хэрэгжилтийг ханган ажиллаж, үр дүнг тайлагнахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Отгонжаргал)-д, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын орлогч дарга (Ч.Сугармаа)-д тус тус үүрэг болгосугай.

12. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2021 оны А/98, А/99, А/100 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



П.ГАНЧИМЭГ

Сумын Засаг даргын 2021 оны 06
сарын 08-ны өдрийн 1102 дугаар
захирамжийн хавсралт



Хязгаарлалт тогтоох төрийн байгууллага, хуулийн этгээд, иргэдийн
үйл ажиллагааны жагсаалт

№	Үйл ажиллагаа	Тавигдах шаардлага	
1	Төрийн болон нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаа	Ажлын байранд 30, гэрээр 70 хувь нь ажиллах	
2	Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газар /ресторан, цайны газар, буфет, явуулын үйлчилгээтэй хоолны газар	Хүргэлтээр	
3	Жагсаал цуглаан, уралдаан тэмцээн	Бүрэн хориглох	
4	Бүх төрлийн баяр ёслол, тэмдэглэлт ой, байгууллага хамт олны аялал зугаалга, хурим найр, цайллага, хүлээн авалт, Уул овоо тахилгын арга хэмжээ		
5	Бүх төрлийн баар		
6	Өргөтгөсөн болон үзэсгэлэн худалдаа		
7	Цахим, автомат тоглоомын газар, бүх төрлийн тоглоомын төв		
8	Бүх төрлийн танхимын сургалтын үйл ажиллагаа		
9	Соёл, урлагийн арга хэмжээ, үзвэр үйлчилгээ		
10	Чийрэгжүүлэх, бялдаржуулах төв		
11	Зочид буудал		
12	Шашны зан үйл, сүм хийд, мөргөлийн газрууд		
13	Олимп, тив, дэлхий, олон улсын тэмцээний бэлтгэлээс бусад биеийн тамир, спортын арга хэмжээ		
14	Хүүхдийн тоглоомын болон сагс, хөл бөмбөгийн талбай		
15	Нийтийн бүжиг ба бүх төрлийн бүжгийн клуб		
16	Агаар салхинд гарах		Зөвхөн гэр бүлийн хүрээнд зөвшөөрөх /нэг өрх/
17	Буяны ажлаар бусад орон нутгаас ирэх		2 автомашин 10 хүртэл иргэнийг ирэхийг зөвшөөрөх
18	Буяны ажлын үед	Автомашин 6, иргэн 20-оос дээшгүй байхыг зөвшөөрөх	